



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/281

Хэрлэн сум

Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль зохион байгуулахад хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.2, 32.1.3, 32.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Шадар сайд, аймгийн Засаг даргатай 2025 онд байгуулсан хамтран ажиллах гэрээ, батлагдсан хуваарь, төлөвлөгөө, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2024 оны 1/2736 дугаар албан бичиг, 2023 оны А/412 дугаар тушаалын дагуу орон нутгийн бүх шатны Засаг дарга, Онцгой комиссын гишүүд, аж ахуй нэгж байгууллагын удирдлага, томилгоот бүрэлдэхүүнийг гамшгаас хамгаалах менежментийн болон болон иргэд, олон нийтийг аюулгүй амьдрах ухаанд сургаж дадлагажуулах зорилгоор зохион байгуулагдах гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль шаардагдах 80,000,000 (наян сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Иж бүрэн сургуульд шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай


3. Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуульд хамрагдах аймаг, сумын онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, аж, ахуй нэгж, байгууллагын хамтын ажиллагааг уялдуулан зохион байгуулалтаар хангаж, гамшгаас хамгаалах иж бүрэн болон команд штабын сургууль, дадлага зохион байгуулах зааврыг мөрдөж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга (хурандаа Ж.Эрдэнэбат)-д үүрэг болгосугай.

4. Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуульд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааг хэрэгжүүлэх зардлын гамшигтай тэмцэх чадавхыг нэмэгдүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Н.Үнэнбат)-д зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Өнөрцолмон)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

ДАЮУРБУНЬ



05
1287
Аймгийн Засаг даргын 2025 оны
дугаар сарын 19-ний өдрийн
дугаар захирамжийн хавсралт

ХЭНТИЙ АЙМАГТ ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ ГАМШГААС
ХАМГААЛАХ ИЖ БҮРЭН СУРГУУЛЬД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зориулалт	Нийт мөнгөн дүн	Хянасан
1	Хулдаасан хэвлэл, ажлын зураг хэвлэлийн зардал	6,900,000	
2	Тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн зардал	6,350,000	
3	Бичиг хэргийн зардал	2,500,000	
4	Шатахууны зардал	20,950,000	
5	Цай, кофе, ус, ундааны зардал	5,100,000	
6	Хоолны зардал	4,500,000	
7	Байрны зардал	8,700,000	
8	Иж бүрэн сургуулийн бэлтгэл ажлыг сумдад хангуулах, сургалт зохион байгуулах	10,000,000	
9	Нисдэг тэрэгний	15,000,000	
Нийт дүн		80,000,000	